# ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER


facebook.com/Rtcc.m0n
http://rtcc.mrtd.gov.mn
info@rtcc.mrtd.gov.mn
+976 77244409


## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2024 оны 06 дугаар сарын дугаар

## Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, тайлан мэдээг танилцуулах




2024 оны 05 дугаар сарын зурмагийн тасалдлын тайлан гарган, СХГ-д, 2024 оны 05 дугаар сарын нэгдсэн зурмагт дүн шинжилгээ хийн, тайланг суурь бүтэц эзэмшигч байгууллагуудад болон ТЗДТБЗГ-д тус тус танилцуулсан. Нэгдсэн зурмагийн дүн шинжилгээний хурлыг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, төлөөллийн саналыг тусгасан шийдвэрийг 06 дугаар сарын 11 өдөр албан бичгээр төмөр замын байгууллагуудад хүргүүлсэн.

Мидлинг тээврийн гүйцэтгэлийг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Нэгдсэн зурмагийн дүнгийн хуралд оролцогчдод танилцуулж, 2024 оны эхний 5 сарын байдлаар гүйцэтгэлийн тайланг гарган, ТЗДТБЗГ-д танилцуулсан. Хилийн болон суурь бүтэц хоорондын галт тэрэг солилцоо, экспортын ачаа, тасалдалын инфографик мэдээг 6 дугаар сарын 1,17-ны өдрүүдэд гарган олон нийтэд танилцуулсан. „Монгол улсын сүлжээнд галт тэрэг дугаарлах заавар“-ын төслийг 2024 оын 06 дугаар сарын 20-ны өдөр „МТЗ“ ТӨХК-ны А зааланд танилцуулан, хэлэлцүүлэг зохион байгуулсан.



## Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас:




“Тавантолгой төмөр зам“ ХХК-ны Тавантолгой өртөөнд суурилуулсан 5Т буюу хөдөлгөөний аюулгүй байдлын системтэй танилцсан. Үүнд AEI дугаар таних систем, Унжсан эд анги илрүүлэх систем, хос дугуйн цохилт ачааллыг илрүүлэх системүүдтэй тус тус танилцав. Тавантолгой-Гашуунсух айт чиглэлд 2024.06.22-ны өдөр аяласан 1150 (тэгш),




1151 (сондгой) дугаартай галт тэрэгний бүрэлдэхүүн дэх 20605549, 20604468 дугаартай ачааны тавцант вагоны 18-9855 загварын тэргэнцэр, Цогццэций-Цагаанцав-Ханги чиглэлд 2024.06.23-ны өдөр аялсан 1061 дугаар галт тэрэгний бүрэлдэхүүн дэх 86001252 дугаартай хагас вагоны 18-100 загварын тэргэнцэрийн хажуу аралд STLIS3DH маркийн чичиргээ хэмжих төхөөрөмжийг суурилуулж туршилтыг зохион байгуулсан. ТТ-ГС чиглэлийн туршилт 467 километрийн зайнд 11 цаг үргэлж 20.3 сая, мөр чичиргээний өгөгдөл цуглуулсан.





## “Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, ЗТХЯ-ыг мэдээллээр хангах” ажлын хүрээнд:



“Эм ай ар ти эс хермес” ХХК-д 2024.06.03-ний 460 дугаартай албан бичгээр худалдан авч буй 50 хагас вагонд урьдчилан дугаар олгосон, “Тавантолгой төмөр зам” ХХК-д 2024.06.11-ний 470 дугаартай албан бичгээр ачааны вагоны мэдээлэлээр хариу хүргүүлсэн.

Тусгай хөдлөх бүрэлдэхүүн, зүтгүүрийн нэгдсэн тооллого хийж, үр дүнг ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-т хүргүүлсэн.



## "Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн санд хоногийн 750 мэдээ, сарын 60 мэдээг бүрдүүлж мэдээллийн нэгдсэн санд байршиж байна. ЗТХ-ийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”, ЗТХ-ийн 2021 оны “Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл авах, мэдээллийн сан бий болгох заавар, маягт, нөхөх заавар, үзүүлэлт батлах тухай” А/93 дугаар тушаалын хүрээнд ЗТХЯ-нд сарын статистик мэдээг албан бичиг болон цахим шуудангаар хүргэж тайлагнасан. Суурь бүтэц эзэмшигчийн тээвэрлэсэн ачааны хэмжээ (импорт, экспорт, дамжин өнгөрсөн, орон нутаг-тонн), чингэлэг тээвэрлэлт (импорт, экспорт, орон нутаг, транзит-тонн), зорчигч тээвэрлэлт (олон улс, орон нутаг-хүн) 2024 оны 05 дугаар сарын ачаа тээврийн статистик мэдээг нэгтгэн болосруулж 2024 оны 06 дугаар сарын 20-ний өдөр төвийн цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулж мэдээлсэн.





Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс